



УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



2025 он






Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангаас товч танилцуулга мэдээлэл


Говьсүмбэр аймагт 2024 онд 118,369.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. Үүнээс 30,268.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээ аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчид эрх шилжиж хэрэгжсэн байна.

Нийт батлагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг салбараар нь ангилж үзвэл:



Говьсүмбэр аймагт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг өмнөх онтой харьцуулбал:

сая төгрөгөөр





Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангаас товч танилцуулга мэдээлэл




Аудитад Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар батлагдаж Говьсүмбэр аймагт эрх шилжин хэрэгжсэн 30,268.9 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хамруулсан.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН



Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн саналаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг цахим системээр аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцсон байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Политехник коллежийн тоног төхөөрөмж нэр, зориулалттай батлагдсан төслөөс тавилга эд хогшил, хангамжийн материал худалдан авч зориулалтыг нь өөрчилсөн байна.



Төсвийг бүсчилсэн байдлаар төлөвлөж хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс Говьсүмбэр, Дундговь аймагт хэрэгжихээр батлагдсан 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төслөөс 206.0 сая төгрөгийг Говьсүмбэр аймагт хуваарилсан байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн боловсруулаагүй байна.



Үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг бодитоор үнэлээгүй, хуульд заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Он дамжин хэрэгжиж буй 3 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаандаа хэрэгжээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.





Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангаас товч танилцуулга мэдээлэл

АУДИТЫН ШИЙДВЭР

Аудитаар нийт 689.1 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлж дараах байдлаар шийдвэрлэсэн.



2 зөрчилд 4 зөвлөмж /холбогдох албан тушаалтнуудад/



535.2 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага



151.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, хариуцлага тооцуулах албан шаардлага



2.0 сая төгрөгийн төлбөрийн акт

АУДИТЫН ДҮГНЭЛТ



Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт өмнөх оноос сайжирсан, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн хэдий ч зөрчлийн хэмжээ буурахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашигтай байдалд сөргөөр нөлөөлж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ



1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд дотоод хяналт хэрэгжүүлэх, санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулж олгох



2. Хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсэгт тухайн байгууллагын дарга удирдлагаас гадна мэргэжлийн хүнийг томилж байлцуулах, ажлын хэсгийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлж, хүлээн авсан төсөл, арга хэмжээнд алдаа зөрчил илэрсэн бол хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх



3. Захиалагчаас үнэлгээний хороонд үнэлгээ хийхэд шаардлагатай баримт материал, техникийн тодорхойлолтын хамт зах зээлийн үнийн болон жишиг үнийн судалгааг хүргүүлдэг байх, худалдан авах ажиллагааны үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллах



3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлж буй хөрөнгийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолттой тулгаж хүлээн авах, хүлээн авсан тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд дотоод хяналт хэрэгжүүлэх

